ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДУА-2026/24/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

**0**

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ....2**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ....4**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/....4**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/....5**

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/....6**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/....8**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....9**

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ....10**

**3.1 Төлбөрийн акт**....10

**3.2 Зөвлөмж**....14

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ....16**

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.02 № 08

танай ______ -ны № ______ -т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.ЗУЛБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад төсвөөс олгох санхүүжилтийг 204.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь өмнөх оноос цалин хөлс болон нэмэгдэл урамшил, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд өссөнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй. Харин тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ нь 165.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй орлого хүлээн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй

4826050028

болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 бүлэг, 10 зорилт, 43 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 311,275,233.35 | 243,097,553.74 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 11,856,606.33 | 2,697,946.00 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 11,856,606.33 | 2,697,946.00 |
| 3121 | Төгрөг | 11,856,606.33 | 2,697,946.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 18,660.33 | |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 11,837,946.00 | 2,697,946.00 |
| 33 | АВЛАГА | 52,784,536.90 | 49,059,677.92 |
| 335 | Бусад авлага | 52,784,536.90 | 49,059,677.92 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 52,784,536.90 | 49,059,677.92 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 236,634,090.12 | 181,339,929.82 |
| 351 | Түүхий эд материал | 37,127,730.19 | |
| 3513 | Эм боох материал | 37,127,730.19 | |
| 354 | Хангамжийн материал | 100,056,359.93 | 81,889,929.82 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 5,949,257.27 | 5,010,480.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 92,299,502.66 | 76,715,449.82 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 127,600.00 | |
| 3545 | Барилгын засварын материал | | 164,000.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 1,680,000.00 | |
| 356 | Мал амьтад | 99,450,000.00 | 99,450,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| 369 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 10,000,000.00 | 10,000,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,189,534,083.06 | 1,076,332,137.20 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,189,534,083.06 | 1,076,332,137.20 |
| 392 | Биет хөрөнгө | 1,182,822,183.02 | 1,071,152,562.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 959,531,091.31 | 960,678,412.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (272,486,934.92) | (325,154,864.10) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 322,358,800.00 | 314,104,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (108,631,201.66) | (139,651,908.32) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 185,634,518.99 | 197,709,720.93 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (57,909,511.93) | (58,993,655.35) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 128,571,309.20 | 118,886,309.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,836,784.66) | (36,490,426.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 72,834,146.92 | 61,564,122.19 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (13,243,250.23) | (21,499,148.73) |
| 393 | Биет бус хөрөнгө | 6,711,900.04 | 5,179,575.08 |
| 39301 | Программ хангамж | 5,811,625.00 | 5,236,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,257,324.96) | (2,214,649.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2,157,600.00 | 2,157,600.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,500,809,316.41 | 1,319,429,690.94 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 13,695,745.10 | 14,172,859.77 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 13,695,745.10 | 14,172,859.77 |
| 413 | Өглөг | 13,695,745.10 | 14,172,859.77 |
| 4131 | Ажилчидтай холбогдсон өглөг | 6,336,540.43 | 396,612.40 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 340,000.00 | 11,760,047.37 |
| 4136 | Бусад өглөг | 7,019,204.67 | 2,016,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 7,019,204.67 | 2,016,200.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,487,113,571.31 | 1,305,256,831.17 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,487,113,571.31 | 1,305,256,831.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 410,438,374.38 | 410,438,374.38 |
| 5E+05 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 410,438,374.38 | 410,438,374.38 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 977,636,135.23 | 795,779,395.09 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 977,636,135.23 | 972,594,252.66 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | (176,814,857.57) |

| | | | |
|---|---|---|---|
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 99,039,061.70 | 99,039,061.70 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,500,809,316.41 | 1,319,429,690.94 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,434,947,607.34 | 1,226,210,642.30 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 556,414,834.34 | 165,648,948.30 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 556,414,834.34 | 165,648,948.30 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 63,803,197.23 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,000,000.00 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 52,784,536.90 | |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 18,660.33 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 453,683,406.91 | 95,073,948.30 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 38,928,230.20 | 70,575,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 878,532,773.00 | 1,060,561,694.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 75,557,773.00 | 52,973,994.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 32,860,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,816,655.00 | 13,273,409.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,881,118.00 | 39,700,585.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 802,975,000.00 | 1,007,587,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 802,975,000.00 | 712,332,800.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | | 295,254,900.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,019,083,178.63 | 1,307,308,638.99 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,019,083,178.63 | 1,307,308,638.99 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 898,929,429.26 | 1,105,038,568.42 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 443,597,852.16 | 534,657,287.36 |
| 210101 | Үндсэн цалин | 271,602,375.72 | 303,500,561.15 |
| 210102 | Нэмэгдэл | 125,186,830.76 | 162,972,088.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 4,385,000.00 |
| 210104 | Урамшуулал | 27,657,809.88 | 38,572,596.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,150,835.80 | 25,227,041.54 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,225,381.17 | 62,325,249.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,899,506.03 | 42,353,055.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,453,045.40 | 5,437,765.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,226,522.71 | 2,747,231.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,924,685.41 | 2,334,600.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,721,621.62 | 9,452,596.81 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,844,578.90 | 21,279,528.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,612,553.90 | 7,984,061.45 |
| 210302 | Түлш, халаалт | 10,737,025.00 | 12,413,467.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 495,000.00 | 882,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 70,221,174.97 | 88,288,410.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,388,300.00 | 2,632,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,821,200.00 | 19,270,050.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,855,418.97 | 1,455,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,659,100.00 | 1,107,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 16,497,156.00 | 2,714,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 61,109,760.30 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 26,891,500.00 | 9,077,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,891,500.00 | 9,077,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,774,000.00 | 15,220,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,774,000.00 | 15,220,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,327,324.60 | 30,573,314.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,021,350.00 | 28,829,668.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 916,000.00 | 680,210.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 196,685.60 | 295,827.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 222,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 94,289.00 | 95,609.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 249,047,617.46 | 343,616,878.09 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 118,125,213.60 | 158,711,844.81 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 666,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 130,922,403.86 | 184,239,033.28 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 120,153,749.37 | 202,270,070.57 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 52,007,850.00 | 8,550,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 11,000,000.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,400,000.00 | 8,250,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 4,225,850.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,782,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,600,000.00 | 300,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 68,145,899.37 | 193,720,070.57 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68,145,899.37 | 193,720,070.57 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 415,864,428.71 | (81,097,996.69) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 30,095,817.07 | 95,716,860.88 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | | 24,036,860.88 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 7,415,817.07 | |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | 22,680,000.00 | 71,680,000.00 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (30,095,817.07) | (95,716,860.88) |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 385,768,611.64 | (176,814,857.57) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 889,551,433.33 | 1,088,307,077.61 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 11,018,660.33 | |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 11,018,660.33 | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 11,018,660.33 | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,000,000.00 | |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 18,660.33 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 878,532,773.00 | 1,088,307,077.61 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 75,557,773.00 | 80,719,377.61 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 32,860,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 35,816,655.00 | 13,273,409.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,881,118.00 | 67,445,968.61 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 802,975,000.00 | 1,007,587,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 802,975,000.00 | 712,332,800.00 |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | | 295,254,900.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 874,788,240.03 | 1,097,465,737.94 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 874,788,240.03 | 1,097,465,737.94 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 754,634,490.66 | 871,175,142.74 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 440,043,363.42 | 545,639,097.96 |
| 210101 | Үндсэн цалин | 271,602,375.72 | 308,542,443.72 |
| 210102 | Нэмэгдэл | 121,957,931.48 | 168,912,016.70 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 4,385,000.00 |
| 210104 | Урамшуулал | 27,516,615.88 | 38,572,596.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,966,440.34 | 25,227,041.54 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,025,381.17 | 62,325,249.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,443,476.03 | 42,353,055.86 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,517,045.40 | 5,437,765.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,258,552.71 | 2,747,231.26 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,956,685.41 | 2,334,600.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,849,621.62 | 9,452,596.81 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,844,578.90 | 21,279,528.95 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,612,553.90 | 7,984,061.45 |
| 210302 | Түлш, халаалт | 10,737,025.00 | 12,413,467.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 495,000.00 | 882,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 45,939,368.97 | 22,361,002.63 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,391,900.00 | 2,671,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,694,700.00 | 15,557,302.63 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,855,418.97 | 1,455,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,907,850.00 | 793,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,089,500.00 | 1,884,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,960,700.00 | 6,806,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,960,700.00 | 6,806,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,434,000.00 | 11,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 17,434,000.00 | 11,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 20,327,324.60 | 30,573,314.20 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 19,021,350.00 | 28,829,668.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 916,000.00 | 680,210.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 196,685.60 | 295,827.20 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 222,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 94,289.00 | 95,609.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,059,773.60 | 171,190,749.48 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 138,059,773.60 | 170,524,749.48 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 666,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 120,153,749.37 | 226,290,595.20 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 52,007,850.00 | 8,550,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 11,000,000.00 | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,400,000.00 | 8,250,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 4,225,850.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,782,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,600,000.00 | 300,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 68,145,899.37 | 217,740,595.20 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 68,145,899.37 | 193,720,070.57 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 24,020,524.63 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 14,763,193.30 | (9,158,660.33) |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 11,000,000.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 11,000,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,000,000.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (11,000,000.00) | |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 3,763,193.30 | (9,158,660.33) |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 8,083,946.00 | 11,856,606.33 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 11,856,606.33 | 2,697,946.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 410,438,374.38 | 99,039,061.70 | 977,636,135.23 | 1,487,113,571.31 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (5,041,882.57) | (5,041,882.57) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| 5 | Тайлант үеийн үр дүн | | | (176,814,857.57) | (176,814,857.57) |
| 6 | 2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 410,438,374.38 | 99,039,061.70 | 977,636,135.23 | 1,487,113,571.31 |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | (5,041,882.57) | (5,041,882.57) |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 9 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| 10 | Тайлант үеийн үр дүн | | | (176,814,857.57) | (176,814,857.57) |
| 11 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 410,438,374.38 | 99,039,061.70 | 795,779,395.09 | 1,305,256,831.17 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн |
|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,007,587,700.00 | 813,886,289.76 | 193,701,410.24 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,007,587,700.00 | 813,886,289.76 | 193,701,410.24 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 989,187,700.00 | 805,336,289.76 | 183,851,410.24 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 585,359,800.00 | 545,639,097.96 | 39,720,702.04 |
| 210101 | Үндсэн цалин | 305,512,300.00 | 308,542,443.72 | -3,030,143.72 |
| 210102 | Нэмэгдэл | 213,110,700.00 | 168,912,016.70 | 44,198,683.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,260,000.00 | 4,385,000.00 | 5,875,000.00 |
| 210104 | Урамшуулал | 28,962,600.00 | 38,572,596.00 | -9,609,996.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 27,514,200.00 | 25,227,041.54 | 2,287,158.46 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 71,887,600.00 | 62,325,249.52 | 9,562,350.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 47,021,300.00 | 42,353,055.86 | 4,668,244.14 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,216,600.00 | 5,437,765.10 | 778,834.90 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,108,300.00 | 2,747,231.26 | 361,068.74 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,108,300.00 | 2,334,600.49 | 773,699.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,433,100.00 | 9,452,596.81 | 2,980,503.19 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 32,596,900.00 | 20,300,777.35 | 12,296,122.65 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 13,569,900.00 | 7,419,809.85 | 6,150,090.15 |
| 210302 | Түлш, халаалт | 18,627,000.00 | 12,413,467.50 | 6,213,532.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 467,500.00 | -67,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,529,000.00 | 21,601,000.00 | 13,928,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,540,000.00 | 2,671,200.00 | 868,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,254,000.00 | 14,797,300.00 | 4,456,700.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,347,000.00 | 1,455,000.00 | 2,892,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,088,000.00 | 793,500.00 | 4,294,500.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,300,000.00 | 1,884,000.00 | 1,416,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,027,000.00 | | 1,027,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,027,000.00 | | 1,027,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,000,000.00 | 6,806,200.00 | 3,193,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,000,000.00 | 6,806,200.00 | 3,193,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 13,600,000.00 | 11,000,000.00 | 2,600,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,600,000.00 | 11,000,000.00 | 2,600,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 46,800,600.00 | 29,499,646.20 | 17,300,953.80 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 43,866,000.00 | 27,756,000.00 | 16,110,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,022,600.00 | 680,210.00 | 342,390.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 536,000.00 | 295,827.20 | 240,172.80 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 226,000.00 | 222,000.00 | 4,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 605,000.00 | 450,000.00 | 155,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 545,000.00 | 95,609.00 | 449,391.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 192,386,800.00 | 108,164,318.73 | 84,222,481.27 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 190,186,800.00 | 107,498,318.73 | 82,688,481.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,200,000.00 | 666,000.00 | 1,534,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,400,000.00 | 8,550,000.00 | 9,850,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,400,000.00 | 8,550,000.00 | 9,850,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,250,000.00 | 8,250,000.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,150,000.00 | 300,000.00 | 9,850,000.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,007,587,700.00 | 813,867,629.43 | 193,720,070.57 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | | | |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 712,341,800.00 | 813,867,629.43 | -101,525,829.43 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 712,341,800.00 | 813,867,629.43 | -101,525,829.43 |
| 133 | ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС | | | |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 295,245,900.00 | | 295,245,900.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 295,245,900.00 | | 295,245,900.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 80,719,377.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 80,719,377.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 56,698,852.98 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 978,751.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 564,251.60 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 414,500.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 760,002.63 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 760,002.63 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,073,668.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,073,668.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,886,430.75 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 53,886,430.75 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 24,020,524.63 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 24,020,524.63 |

| | | |
|---|---|---|
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 24,020,524.63 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 80,719,377.61 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 80,719,377.61 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,273,409.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 67,445,968.61 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 85,119.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 50,652.8 мянган төгрөгийн 3 зөрчлийг аудитын явцад залруулан, 34,466.2 мянган төгрөгийн 4 зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

***Залруулагдаагүй алдаа:***

### 3.1 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй 16,050.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *(дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг;
2. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах гэрээ байгуулсан ч гэрээний дагуу төлөх 5,500.0 мянган төгрөгийн төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), 20.2.6-д (*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*) заасныг;
3. Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа авто машинд зарцуулсан тээвэр, шатахууны 4,786.8 мянган төгрөгийн зардлыг хяналтгүй зарцуулсан, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т *(батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих)*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т *(Аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат, дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна),* Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 1-р хавсралт *(Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг үндэслэн тогтоож, мөрдөж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог тогтсон хугацаанд бодож, тооцоо бодсон актыг үйлдэж баталгаажуулах)* заасныг;
4. Эм эргэлтийн санд хийсэн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоогдсон 8,129.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг төлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т *(батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих)*, 16.5.5-д *(батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах)* заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.*

***Залруулсан алдаа:***

1. Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн 5,041.8 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд цалингийн зардлаар илүү тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т *(холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) заасныг;

2. Бусдад худалдан борлуулсан 37,127.7 мянган төгрөгийн эм, боох материалыг бараа материалын данснаас хасаагүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-т *(Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана)*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д *(эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах)* заасныг;
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан 8,483.2 мянган төгрөгийн зардал (үндсэн хөрөнгө) -ыг илүү тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3-т *(холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах)* заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад бүрэн залруулсан..*

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 12,916.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 156.9 мянган төгрөгөөр бага тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Өмнөх оны нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг тайлант онд цалингийн зардлаар илүү тайлагнасан. | 1 | 5,041.9 | | | 1 | 5,041.9 | 1 | 5,041.9 | | |
| Бусдад худалдан борлуулсан эм, боох материалыг бараа материалын данснаас хасаагүй. | 1 | 37,127.7 | | | 1 | 37,127.7 | 1 | 37,127.7 | | |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй гарсан зардал (үндсэн хөрөнгө) -ыг илүү тайлагнасан. | 1 | 8,483.2 | | | 1 | 8,483.2 | 1 | 8,483.2 | | |
| **Дүн** | **3** | **50,652.8** | | | **3** | **50,652.8** | **3** | **50,652.8** | | |

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлан дахь насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй. | 1 | 16,050.0 | | | 1 | 16,050.0 | | | | |
| Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах гэрээ байгуулсан ч гэрээний дагуу төлөх төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй. | 1 | 5,500.0 | | | 1 | 5,500.0 | | | | |
| Эм эргэлтийн санд хийсэн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд тогтоогдсон төлбөрийн актыг төлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 8,129.4 | | | 1 | 8,129.4 | | | | |
| Байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа авто машинд зарцуулсан тээвэр, шатахууны зардлыг хяналтгүй зарцуулсан, зарцуулалтын тооцоог хууль журмын дагуу бодож баталгаажуулаагүй. | 1 | 4,786.8 | | | 1 | 4,786.8 | | | | |
| **Дүн** | **4** | **34,466.2** | | | **4** | **34,466.2** | | | | |